



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/6

Улаанбаатар хот

Мэдээлэл сурталчилгааны талаар авах
арга хэмжээний тухай

“Жендэрийн үндэсний хорооны дүрэм” -ийн 2.9, 5.1, 5.1.11-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Т.Энхбаяр/-д дараахь арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.
 - 1.1. Жендэрийн үндэсний хорооны үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчилах ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран тасралтгүй, үр дүнтэй зохион байгуулах;
 - 1.2. Мэдээлэл сурталчилгааны ажлын үр дүн, тайланг хорооны хуралд жил бүр танилцуулах.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хэвлэл мэдээллийн зөвлөл” байгуулах тухай Жендэрийн үндэсний хорооны 2018 оны 03 дугаар сарын 15- ны өдрийн 2 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ ДАРГА



Л.ОЮУН-ЭРДЭНЭ